

Цөм өгүүлбэр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Өгүүлбэрийг бүтцээр нь энгийн ба нийлмэл өгүүлбэр гэж ангилна. Үйл үгийн тоогоор нь энгийн ба нийлмэл өгүүлбэрийг ялгана. Өгүүлбэрийн цөм бүтцийг бүрдүүлэгч өгүүлэгдэхүүн (хэн, юу), шууд тусагдахуун (хэнийг, юуг), өгүүлэхүүн (яав, яасан,) гишүүдийг гол гишүүд гэнэ. Тусгай таних тэмдгээр гишүүдийн доогуур нь зурна. Гол гишүүдээс бүтсэн өгүүлбэрийг цөм өгүүлбэр гэнэ.

Дасгал 23. Өгүүлбэрийг бүтцээр нь ялган таниарай.**Алхам 1. Хоёр хэсэг өгүүлбэрийн ялгааг олоорой. Зөв харгалзуулна уу.**

- | | |
|--|--|
| <p>а. Сумын төвийн байшингууд цуурайтна. Сургууль цэцэрлэг эл хуль болно. Сумын улаан булангийн үүдэнд сар сар мотор дуугарна</p> <p>б. Яав, машин явахаар сум доргих шиг чимээ гарна. Нугас цуурга гажсан сэнсрээ модон хаалга салхинаа савлана. Ирэх зуны явдлыг зөгнөж эмгэд гаднаа нарлана. Илүү гэр их гэрийн хооронд явж энэ тэрхнийг хийнэ. Тэгээд гэртээ орж тээрмийн буудай хуурна.</p> | <p>1. Өгүүлбэр тус бүр нь 2-оос дээш үйл үгтэй нийлмэл өгүүлбэр</p> <p>2. Өгүүлбэр бүр нь зөвхөн нэг үйл үгтэй энгийн өгүүлбэр</p> |
|--|--|

Алхам 2. Алхам 1-ийн “б” хэсэгт байгаа өгүүлбэрүүдийг үйл үгийн тоогоор нь энгийн өгүүлбэр болгож задлаарай.

Нийлмэл өгүүлбэр: Яав, машин явахаар сум доргих шиг чимээ гарна.
Энгийн өгүүлбэр: Яав, машин явна. Сум доргих шиг чимээ гарна.

Нийлмэл өгүүлбэр: Нугас цуурга гажсан сэнсрээ модон хаалга салхинаа савлана.
Энгийн өгүүлбэр:

Нийлмэл өгүүлбэр: Ирэх зуны явдлыг зөгнөж эмгэд гаднаа нарлана.
Энгийн өгүүлбэр:

Нийлмэл өгүүлбэр: Илүү гэр их гэрийн хооронд явж энэ тэрхнийг хийнэ.
Энгийн өгүүлбэр:

Нийлмэл өгүүлбэр: Тэгээд гэртээ орж тээрмийн буудай хуурна.
Энгийн өгүүлбэр:

Дасгал 24. Өгүүлбэрийн гол гишүүдийг асуултаар ялган таниарай.**Алхам 1. Өгүүлбэр дэх үгсэд асуулт тавиарай.**

Юуны? Юуны? Юу? Яана?

Сумын төвийн байшингууд цуурайтна. Сургууль цэцэрлэг эл хуль болно. Сумын улаан булангийн үүдэнд сар сар мотор дуугарна. Ирэх зуны явдлыг зөгнөнө. Эмгэд гаднаа нарлана.

Алхам 2. Өгүүлбэрүүдээс гол гишүүдийг ялган, доогуур нь зураарай.

Өгүүлбэр	Өгүүлбэрийн цөм бүтэц		
	хэн/юу?	хэнийг/юуг?	яав? яана?
Сумын төвийн байшингууд цуурайтна.	<u>Байшингууд</u>		<u>цуурайтна.</u>
Сургууль цэцэрлэг эл хуль болно.	<u>Сургууль</u>		<u>эл хуль болно.</u>
Сумын улаан булангийн үүдэнд сар сар мотор дуугарна.			
Эмгэд ирэх зуны явдлыг зөгнөнө.			
Эмгэд гаднаа нарлана.			

Алхам 3. Өмнөх алхамд байгаа хүснэгтээ ажиглаж, өгүүлбэрийн гол гишүүдийн онцлогийг тайлбарлаарай. Хүснэгтийг гүйцээнэ үү.

	өгүүлэгдэхүүн	шууд тусагдахуун	өгүүлэхүүн
Илрэх үгийн аймаг	жинхэнэ нэр		
Утга	үйлийн эзэн	Үйлэнд шууд өртөгч	Үйл хөдлөл
Асуулт	хэн? юу?		
Хувилал	нэрлэхийн тийн ялгал		
Тэмдэг	-----	=====

Алхам 4. Цөм өгүүлбэрийн ангиллын тухай ойлголтыг дэвтэртээ бичиж аваарай.

Гол гишүүдээс бүтсэн өгүүлбэрүүдийг цөм өгүүлбэр гэнэ. Цөм өгүүлбэр нь тусах үйл үгтэй байвал 3 бүрэлдэхүүнт, эс тусах үйл үгтэй бол 2 бүрэлдэхүүнт өгүүлбэр гэнэ. Өмнөө хэнийг, юуг гэсэн асуултад хариулагдах үгийг захирч байгаа үйл үгийг тусах (яриаг **сонсох**, номыг **унших**), өмнөө заахын тийн ялгалтай нэр үгийг захирч чадахгүй байвал эс тусах (гадаа **суух**, гэрээс **ирэх**) үйл үг гэнэ.

Алхам 5. Дараах зургаар цөм өгүүлбэр зохиогоод, бүрэлдэхүүнийг тодорхойлоорой.

		
3		2
Хүүхдүүд (хэн) бөмбөг (юуг) тоглож байна. (яаж байна)		Тэд (хэн) уралдав. (яав)
		

Дууссан:онсарөдөр